

Монгол улс, БНХАУ-ын боловсролын хамтын ажиллагааны түүхэн хөгжил

Чу.Байгалмаа^{a*}, Qinggele^b

^aМУБИС, Боловсрол Судлалын Сургууль, Боловсрол Судлал Аргазүйн Тэнхим

^bӨвөр Монголын Анагаах Ухааны Их Сургуулийн Гадаад Харилцааны Алба

Хураангуй

Сүүлийн жилүүдэд Монгол, Хятад хоёр улсын боловсролын харилцаа эрчимтэй өргөжиж байгаа хэдий ч энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил төдийлөн хийгдээгүй учраас хоёр улсын боловсролын харилцааны талаар ном гарын авлага, судалгаа шинжилгээний бүтээл монгол, хятад хэлээр байхгүй байгаа нь энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажлыг хийхийг цаг үе биднээс шаардаж байна. Энэхүү өгүүлэлээр Монгол, Хятад хоёр улсын 1949-2017 оны хооронд боловсролын хамтын ажиллагаатай холбогдох түүхэн баримтуудад шинжилгээ хийсний үндсэн дээр түүхэн үечлэлийг тогтоосон. Бидний судалгааны асуулт Монгол болон БНХАУ-ын боловсролын хамтын ажиллагааг хэрхэн үечилж болох вэ? гэдэгт оршиж байсан. Түүнчлэн боловсрол судлалын агуулгын нэгэн судлагдахуун болох боловсролын түүхийг Монгол улс болон БНХАУ-ын боловсролын хамтын ажиллагаа гэсэн агуулгаар баяжуулсан. Судалгаанд мэдээ баримтын шинжилгээ, системийн шинжилгээ, харьцуулсан судалгааны аргуудыг ашигласан. Судалгааны үр дүнд хоёр улсын боловсролын хамтын ажиллагаа гэсэн сэдвээр боловсрол судлалын салбар шинжлэх ухааныг баяжуулсан төдийгүй энэхүү сэдвийн хүрээнд судалгаа хийж буй судлаачдын ажлыг өргөжүүлэн, дэмжих шаардлагатай байна.

Түлхүүр үг

Боловсролын хамтын ажиллагааны түүхэн үечлэл, социалист хамтын ажиллагаа, үзэл суртлын үл ойлголцлын үе, найрсаг хамтын ажиллагааны үе

Удиртгал

Хятад Монгол хоёр улсын боловсролын хамтын ажиллагааны талаарх түүхийн болон хоёр улсын Засгийн Газрын түвшний эрхзүйн баримтуудад шинжилгээ хийсний үндсэн дээр хамтын ажиллагааны түүхэн үечлэлийг тогтоосон. Мөн боловсрол судлалын дэд салбар болсон боловсролын түүхийн агуулгыг Монгол-Хятадын боловсролын хамтын ажиллагааны түүхэн үечлэл сэдвээр баяжуулсан. Монгол улс БНХАУ хоёр орны боловсролын хамтын ажиллагаа өмнө байгаагүй өргөжин тэлж сайжирч байгаа тул энэхүү боловсролын хамтын ажиллагааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна. Өгүүллийн зорилго нь Монгол улс, БНХАУ-ын 1949-2017 оны хугацааны боловсролын хамтын ажиллагааны түүхийг үечлэхэд оршино. Зорилгодоо хүрэхийн тулд онолын, харьцуулсан болон түүхэн судалгааны, тогтолцооны шинжилгээний аргуудыг тус тус хэрэгжүүлсэн.

Судалгааны арга зүй: *Боловсролын хамтын ажиллагаа бол иргэдийн боловсрох хэрэгцээг хангахтай холбогдон үүсэж буй*

улс төр, засаг захиргаа, эдийн засаг, иргэний асуудлыг шийдвэрлэхэд оролцогчдын мэдээлэл солилцож ойлголцох, хамтын ажиллагааны чиглэл, арга механизмыг төлөвлөн боловсруулах, хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, үнэлэх, хөгжүүлэх хүмүүнлэгийн цогц үйл явц юм. Боловсролын хамтын ажиллагааны төрлүүд нь хүмүүс солилцоо, үндэстэн дамнасан боловсрол (transnational education), мэдээлэл солилцоо, захиргааны шинэчлэл (regulatory reform), хамтын ажиллагааны хөгжил (Mc Kenzie¹, 2008, х.26.) байна.

Зураг 1
Боловсролын хамтын ажиллагааны төрөл



* ✉ baigalmaa0522@msue.edu.mn

1 McKenzie

Монгол улс БНХАУ улс нь харилцаа хамтын ажиллагааны зузаан түүхтэй мөнхийн хөрш учраас хоёр улсын боловсролын хамтын ажиллагааны түүхэн хөгжлийн асуудлыг нэн эртний үеэс эхлэх боломжтой ч 1949-2017 оны хооронд 60 гаруй жилийн хамтын ажиллагаанд холбогдох түүхэн эх сурвалжид он дараалсан шүүж баримтын шинжилгээ хийсэн.

1949 оны 10 дугаар сарын 01-ны өдөр Бээжингийн Тянь Аньмэний талбайд БНХАУ тусгаар тогтнолоо тунхагласан. БНМАУ-ын засгийн газар 1949 оны 10 дугаар сарын 06 өдөр БНХАУ-ын Ардын төв засгийн газарт дипломат харилцаа тогтоох тухай илгээлт бичиг явуулж, 1949 оны 10 дугаар сарын 16-ны өдөр БНХАУ-ын засгийн газраас энэ явдалд баяр хүргэсэн хариу ирүүлсэн (БНХАУ-ын дипломат бодлого, үндсэн зарчим, х.14). Ингэж 1949 оны 10 дугаар сард “БНХАУ, БНМАУ-ын нөхөрсөг харилцан туслах гэрээ”-г байгуулж хоёр улс жинхэнэ улс төрийн харилцаагаа эхлэв. БНМАУ өмнөд хөрш Хятад улстай хэвийн харилцаа тогтоон хөгжүүлэх явдал хувьсгалын бүх жилүүдэд засгийн гадаад бодлогын чухал чиглэл байсан. (Жаргалсайхан, 2009, х.14.)

1950 оны 07 дугаар 03-нд БНМАУ-аас БНХАУ-д суух анхны Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд -Б.Жаргалсайхан БНХАУ-ын дарга Мао Зэдунд итгэмжлэх жуух бичгээ барьсан. 1952 онд Монгол улсад анх удаа хоёр орны найрамдлын өдрүүд болж Хятадын төлөөлөгчид Монголд айлчилж, Хятадын тухай үзэсгэлэн нээгджээ (Болдбаатар, 2014, х.114). 1952.09.28-10.07-нд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбал тэргүүтэй ЗГ-ын төлөөлөгчид Хятадад айлчлан БНХАУ байгуулагдсаны 3 жилийн ойд оролцсон. Хятад Монголын боловсролын солилцоо 1952 оноос эхэлж өнөөг хүртэл маш амжилттай хөгжиж ирсэн

1959 оны Хятад-Монголын соёлын хамтын ажиллагааны дагуу БНХАУ-ын боловсролын салбартай танилцахаар Монголын боловсролын яамны I орлогч сайд тэргүүтэй төлөөлөгчид Бээжин, ӨМӨЗО-д ажиллажээ. 1960 онд Монгол Хятадын найрамдлын нийгэмлэг “БНМАУ-ын ардын боловсрол” гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулжээ.

1961 онд БНХАУ-ын Боловсролын Дэд сайд Дун Чюньцай БНМАУ-ын Боловсролын сайд М.Жамсраны урилгаар Багш нарын III их хуралд оролцсон. 1962 онд хоёр улс хилийн заагаа тодорхойлж, 06 дугаар сарын 22-нд Чингис хааны мэндэлсний 800 жилийн ойг тохиолдуулан эрдэм

шинжилгээний хурлыг хамтран зохион байгуулав.

1960-70 оны үед улс төр, үзэл суртал, соёлын хувьсгалаас үүдэлтэй өдөөн хатгалга, түүхийн гуйвуулга, гүтгэлэг, хилийн зөрчил маргаан, хилийн ойр орчимд цэргийн хээрийн сургууль хийх зэргээс шалтгаалсан үл ойлголцол бий болж 1960-аад оны сүүлчээр хоёр орны харилцаа эрс муудан хурцадсан. 1964 онд Хятадад ревизионист боловсролыг эсэргүүцсэн шинэчлэл эхэлсэн. 1966-1989 оны хооронд Монгол-Хятадын харилцаа хамгийн эдрээтэй, зарим үед ихээхэн түгшүүртэй байсан. Хоёр улс Зөвлөлтөөр дамжин орж ирсэн Европын боловсролын тогтолцоогоор хөгжиж ирсэн ч энэ үед улс төр, үзэл суртлын нөлөөгөөр тодорхой хэмжээгээр тасалдсан. 1966-1976 он БНХАУ-ын түүхийн хамгийн эмгэнэлтэй “соёлын хувьсгалын” хүнд үе байсан. “Улаан хамгаалагчид” хэмээх залуучууд Мао Зэдуны үзлээр өсвөр насныхныг хөөрөгдөж, ахмад үе, нам төр засгийн удирдагчид үйлдвэрийн дарга, сургуулийн захирал, багш нарынх нь эсрэг турхирч, улс даяар үймээн дэгдээж, нийгмийг гүн хямрал цочролд, эдийн засгийг уналтад оруулжээ.

1977 оноос Хятадад боловсрол социалист модернизацичлалын бүтээн байгуулалтад үйлчлэх ёстой гэсэн хандлагатай шинэчлэл эхэлсэн. 1978 оноос Зөвлөлт-Хятадын хоорондох “хүйтэн дайн” дуусгавар болж, ХКНТХ-ны 1978 оны III бүгд хурлаас “Хятад өөрөө хөгжих үндсэн дээр дэлхийн олон улстай эрх тэгш харилцан ашигтай, эдийн засгийн хамтын ажиллагааг идэвхтэй хэрэгжүүлж, дэлхийн тэргүүний технологийг ашиглан, боловсролыг бэхжүүлнэ (Жаргалсайхан, 2009, х.99) гэж заасан. 1985 оноос ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр БНХАУ-ын улс төрийн харилцаа сэргэж хилийн худалдааг нэмэгдүүлэхэд анхаарч Дэн Сяопин “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэндэд зарцуулах хөрөнгөө жилээс жилд нэмэгдүүлэхгүй бол бид модерацийг өрнүүлж чадахгүй” онцлон тэмдэглэсний дагуу 1985 онд ХКНТХ боловсролын хөрөнгө оруулалтыг ихэсгэн жил бүх ахиулахыг заажээ” 1986 оны 06 дугаар сард Хятад улсаас МУ-д суугаа элчин сайд Ли Жүчин болон БНМАУ-ын ГХ-ны дэд сайд Бавуу нар хоёр улсын боловсролын солилцооны гэрээг 1967 оноос хойш анх удаа хийсэн. 1987 онд хориод жил тасалдсан шинжлэх ухаан техникийн харилцааг сэргээж, “1987-1988 оны хоорондох шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны төсөл”-д гарын үсэг зурсан. 1987 оноос БНХАУ, БНХАУ-ын засгийн газар хоорондын соёлын хэлэлцээрийн дагуу БНХАУ-ын Их, дээд

сургуулиас мэргэжилтэн багш нар Монголд багшлах болсон.

Ш.Лувсанвандан тэргүүтэй Монголын эрдэмтдийн төлөөлөгчид ӨМИС-аас зохион байгуулсан ОУ-ын Монгол судлалын анхдугаар хуралд 1987.09.25-нд оролцсон. Ийнхүү хоёр улсын улс төрийн харилцаа бүрэн сэргэхээс өмнө боловсролын харилцаа сэргэсэн юм. 1988 оны 05 дугаар сард БНМАУ-ын ШУА-ийн академич Ш.Нацагдорж ӨМӨЗО-ны БИС-иас зохион байгуулсан “Монголын нууц товчоо” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцов. Мөн сард БНХАУ-ын Соёлын Яамны урлаг соёлын хэлтсийн дарга Фань Цянь тэргүүтэй төлөөлөгчид БНМАУ-ын соёл боловсролын үйл ажиллагаатай танилцав.

1989 онд ХКН ба МАХН хооронд хамтран ажиллах гэрээ байгуулснаар БНХАУ-ын нээлттэй бодлого амжилттай хэрэгжиж, Монголын худалдааны тэргүүлэх түнш болсон төдийгүй боловсролын хамтын ажиллагаа өргөжин хөгжих нөхцөл бүрдсэн. Ийнхүү 1966-1979 оны хооронд түүхэн тодорхой шалтгааны улмаас хэсэг хугацаанд зогсонги зарим үед ихээхэн түгшүүртэй байсан Хятад Монголын харилцаа 1980-аад оны дунд үеэс сэргэж, 1990 он гэхэд бүрэн хэвийн болсон.

1991 оны 11 дүгээр сарын 19-нд БНМАУ-ын БЯ-ны сайд Н.Уртнасан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-д айлчлан 1991-1995 оны боловсролын хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав. 1994 оноос хоёр улс найрсаг харилцаа хамтын ажиллагааны тухай эрх тэгш гэрээ байгуулж, бие биесийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, харилцан үл довтлох талаар тохирсноор хоёр орны харилцаа шинэ шатанд гарч (Очирбат, 1996, х.12) тогтвортой хөгжих үндэс суурийг тавьсан. Мөн онд хоёр улсын ЗГ хооронд Соёлын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг байгуулсан.

1996 оны 4 дүгээр сарын эхээр МУ-ын БСШУЯ-ны сайд С.Төмөр-Очир Хятадад айлчилж, хоёр тал “1996-2000 онд хэрэгжүүлэх Хятад Монголын боловсролын хамтын ажиллагааны гэрээ” байгуулав. 1997 оны 05 дугаар сард МУ-ын Боловсролын Сайдын урилгаар Хятадын соёлын яамны сайд Лю Жонда Монгол улсад нөхөрсөг айлчлал хийсэн. 1998 оны 07 дугаар сарын 17-нд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч Ли Ланьчин МУ-ын БСШУЯ-ны сайд Ч.Сайханбилэг тэргүүтэй төлөөлөгчидтэй Бээжинд уулзан “Хятад Монголын 1998-2000 оны соёл боловсролын солилцоог хэрэгжүүлэх

төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. Мөн 1998 онд хоёр улс дээд боловсролын зэргийг харилцан зөвшөөрөх тухай гэрээ”-г байгуулсан.

2000 онд “Хятадын буцалтгүй тусламжаар Монгол оюутныг сургах хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэн. 2001 оны 06 дугаар сарын 13-нд БНХАУ-ын Боловсролын Яамны урилгаар БСШУЯ-ны сайд А.Цанжид тэргүүтэй төлөөлөгчид Хятадад айлчлав. 2001 онд Хятад Монголын 2001-2003 оны хоорондох соёлын солилцооны хамтын ажиллагааны хэрэгжүүлэлтийн төсөлд гарын үсэг зуржээ. 2001 оны 11 дүгээр сарын 27-30-ны хооронд МУ-ын ШУА-ын урилгаар Хятад улсын ШУА-ийн дэд дарга Ян Байлин Монгол улсад айлчлав. Мөн оны байдлаар Монгол улсаас Хятад улсад 664 оюутан суралцаж байв.

2002 онд БНХАУ-ын Боловсролын Яамны дэд сайд Зян Тяньбао Монгол улсад айлчлав. МУ-ын ЕБС-ийн сурагчдын дунд Хятад хэлний анхдугаар олимпиадыг зохион байгуулав. 2002 онд Монголд Хятад хэлний түвшин тогтоох шалгалтын (HSK) төв байгуулагдсан. 2003 онд БНХАУ-ын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн бакалаврын сургалтад 10, магистр болон докторын сургалтад 32, нийт 42 иргэн шалгаран 100% тэтгэлгээр тус улсад суралцах болжээ. Хятадын соёлын өдрүүдийг 2004 онд Монгол Улсад, Монголын соёлын өдрүүдийг 2005 онд Бээжин болон Тяньжин хотод амжилттай зохион байгуулав. БНХАУ-ын ЗГ-ын тэтгэлгийн уралдаант шалгалтад нийт 375 оролцогч хамрагдан бакалаврын сургалтад 9, магистр болон докторын сургалтад 42, нийт 51 суралцагч шалгаран БНХАУ-ын 100% тэтгэлгээр Хятад улсад суралцах эрх авчээ.

2005 онд “Боловсролын хамтын ажиллагааны гэрээ” байгуулж, МУ-ын ерөнхийлөгч Н.Багабанди БНХАУ-д айлчлан, Хятадын ЗГ-ын зардлаар сургах оюутны тоог 40-өөр нэмэгдүүлж жилд 220 хүн сургахаар болсон. МУ-ын БСШУЯ, БНХАУ-ын БЯ-ны хооронд 2006-2010 онд хэрэгжүүлэх Боловсролын солилцоо, хамтын ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурав (Монгол улс, Шинжлэх Ухааны Академи, 2006, х.5). Хоёр тал “БНХАУ, МУ-ын БСШУЯ хоорондын 2005-2010 хүртэлх боловсролын солилцоо, хамтын ажиллагааны хөтөлбөр” байгуулсан.

2005 онд хоёр улс хамтарч Монгол ардын уртын дууг Гиннесийн номд бүртгүүлсэн нь соёлын хамтын ажиллагаа шинэ шатанд гарсныг харуулсан. Монгол судлал, уламжлалт анагаах ухаан, бэлчээр хамгаалалт, Хөх хот болон Улаанбаатар хот төлөвлөлтийн харьцуулсан судалгаа зэрэг эрдэм шинжилгээний ажлууд

хийгдсэн. ӨМӨЗО жил бүр Монголын 100 оюутныг тэтгэлэгтэй суралцуулах төслийг хэрэгжүүлж эхэлсэн.

2006 оны 05 дугаар 17-нд МУ-ийн ИДС-ийн оюутны дунд Хятад хэлний IV олимпиад зохиогдсон 150 гаруй оюутан оролцов. 2006-2010 оны шинжлэх ухаан техник мэргэжлийн хамтын ажиллагааны гэрээний дагуу Монголын нөхцөлд тохирсон чанартай лууван ургуулах, ургамал судлал, бүрхэвч хамгаалалтын судалгаа зэрэг төслийг хамтран хэрэгжүүлэв. 2006 онд Хятадын ЗГ-аас жилд бакалаврын сургалтад 50, магистр болон докторын сургалтад 50, нийт 100 суралцагчийг шалгаруулан БНХАУ-ын 100% тэтгэлгээр Хятад улсад сургасан.

2007 онд Хятадын бага сургууль, их дээд сургуульд суралцаж байгаа МУ-ын сурагчдын тоо 1551 хүнд хүрсэн. 2008 онд “Хятад хэлний сайн дурын багш нарыг Монголд багшлуулах гэрээ”-г байгуулсан. 2008 оны 04 дүгээр 16-нд МУ-ын БСШУЯ, БНХАУ-ын ЭСЯ, Монголын Хятад хэлний багш нарын холбоо хамтран Хятад хэлний VI олимпиадыг зохион байгуулав. 2009 оны 10 дугаар 09-нд БНХАУ байгуулагдсан, хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойд зориулж МУИС-ийн Күнзийн институтээс “Хятад хэл соёлын судалгаа” ЭШ-ний хурлыг зохион байгуулав.

2010 онд хоёр орны хооронд “Хоёр улсын сургуулиудын төгсөлтийн үнэмлэх дипломыг харилцан зөвшөөрөх гэрээ”-нд засвар оруулсан. 2011 онд “Хоёр улсын боловсролын яам хооронд 2011-2016 оны боловсролын солилцоо хамтын ажиллагааны төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан. 2012 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар БНХАУ-ын ЗГ-аас монголын 350 оюутанд тэтгэлэг олгосон.

2013 оны байдлаар БНХАУ-ын ЗГ-аас тус улсын ИДС-д суралцаж буй Монголын 220 оюутанд тэтгэлэг олгожээ. 2014 онд БНХАУ-ын дарга Си Зиньпин Монгол улсад хийсэн төрийн айлчлалаар Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоож, 2014 оныг “Монгол-Хятадын соёл хүмүүнлэгийн солилцооны жил” болгон зарласан. Хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойд зориулан “Монгол Хятадын хүмүүнлэгийн солилцооны шинэ боломж, шинэ сорилт” ОУ-ын ЭШ-ний хурал зохион байгуулжээ. 2017 оны 6 дугаар сарын байдлаар Хятад улсын 100 гаруй ИДС, 60 гаруй дунд сургуульд Монголын 3629 хүүхэд суралцаж, Монголын 1100 оюутан Хятадын ИДС төгсөж зарим нь Хятад улсад ажиллаж байна.

Зураг 2

Монгол Хятадын хамтын ажиллагааны түүхэн үечлэл



Нэгдүгээр үе. 1949-1962. Энэ үеийн онцлог бол хоёр орон социалист хөгжлийн замаар замнан, хоорондоо социалист харилцааны зарчимд тулгуурлан, харилцан тусалж “дэлхийн социалист системийг бэхжүүлэхэд”-д чиглэж байв. Дипломат харилцаа тогтоосон эхний арав гаруй жилд дээд хэмжээний айлчлалууд хийгдэж, хоёр орны харилцаа найрсагаар хөгжиж байв. Тухайлбал: 1952, 1954, 1959, 1960, 1962 онуудад БНМАУ-ын нам засгийн төлөөлөгчид БНХАУ-д албан ёсны айлчлал хийжээ. Хятадын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Чжоу Энълай 1954, 1960 онд, БНХАУ-ын дэд дарга Чжу Дэ 1954, 1958, 1961 онуудад Монгол улсад албан ёсны айлчлал хийсэн. Эдгээр айлчлалын үр дүнд хоёр орны хооронд 1952 онд “Засгийн газар хоорондын эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээр”, 1960 онд хоёр улсын “Найрамдал харилцан туслалцах гэрээ”, 1962 онд “Хилийн гэрээ” байгуулсан. 1960 оны гэрээ нь анх удаа хоёр орны тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, тэгш эрх, харилцан ашигтай байх зарчмыг тодорхойлсон түүхэн ач холбогдолтой.

Хоёрдугаар үе. 1962-1990. Өнгөрсөн зууны 60-аад оны эхнээс 80-аад оны эцэс хүртэл хоёр орны харилцаа муудаж зогсонги байдалд орж, 1966-1976 оны “соёлын хувьсгалын” үед хурцдаж улмаар сөргөлдөөний байдалд орсон юм. Энэ үед Хятадын зүгээс Монголын газар нутагт өнгөлзсөн халдлага гарч байсан учраас Хятадын аюулаас хамгаалахын тулд ЗХУ-ын цэргийн ангиудыг Монголын нутаг дэвсгэрт байрлуулсан. 80-аад оны сүүлээс хоёр орны харилцаа сэргэж хэвийн байдалд орсон. 1985 оноос хоёр орны худалдааны харилцаа, 1989 оноос улс төрийн харилцаа сэргэж 1989 онд БНХАУ-ын гадаад хэргийн сайд Цянь Цичэнь Монгол улсад ажлын айлчлал хийсэн.

Гуравдугаар үе. 1990-ээд оноос хойш. 1990 онд Монгол улсын ерөнхийлөгч П.Очирбат БНХАУ-д, 1994 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Ли Пэн Монгол улсад албан ёсны айлчлал хийсэн. 1994 онд “Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны

тухай гэрээ” шинэчлэн байгуулагдав. Энэ гэрээ хоёр улс харилцааг шинэ түвшинд гаргах эрхзүйн үндсэн баримт болсон. Хоёр орны өндөр дээд хэмжээний албан ёсны айлчлалууд тасралтгүй явагдаж, БНХАУ-ын дарга, Хятадын дөрөв дэх үеийн удирдагч Ху Жинтао 2003 онд МУ-д төрийн айлчлал хийж, энэ үеэр хоёр улс хооронд “сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцаа” тогтоон хөгжүүлэхээр тохиролцож, хамтарсан мэдэгдэл гаргасан. МУ-ын ерөнхийлөгч Н.Энхбаяр 2005 онд БНХАУ-д айлчилж, хоёр орны харилцааг эдийн засгийн хамтын ажиллагааны

агуулгаар баяжуулах зорилтуудыг тавьсан. 2008 онд Монгол Хятадын дээд хэмжээний уулзалт, МУ-ын УИХ-ын даргын БНХАУ-д, БНХАУ-ын дэд дарга Си Жин Пины МУ-д, 2009 онд МУ-ын ерөнхий сайд С.Баярын БНХАУ-д, ХКН-ын ТХ-ны УТТ-ны Байнгын хорооны гишүүн, Хэ Гуоцяны МУ-д, 2010 онд МУ-ын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн БНХАУ-д, БНХАУ-ын Ерөнхий сайд Вэнь Зябаогийн Монгол Улсад хийсэн айлчлал зэрэг өндөр үр дүнтэй айлчлалууд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Хүснэгт 1

МУ, БНХАУ-ын боловсролын харилцааны гол үйл явдлууд

Үечлэл	Гол үйл явдал
Социалист хамтын ажиллагаа (1949-1962)	Хоёр орон социалист хөгжлийн замаар замнан, хоорондоо социалист харилцааны зарчимд тулгуурлан, харилцан тусалж “дэлхийн социалист системийг бэхжүүлэхэд”-д чиглэж хоёр Зөвлөлтийн боловсролын туршлагаас идэвхтэй суралцаж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийг орчуулан хэрэглэж сургалтын арга барилыг нь судлан нэвтрүүлж байсан. Мао Зедуны “суралцагчдыг ёс зүй, оюун ухаан, бие бялдрын хувьд өв тэгш хөгжихөд туслан, социалист ухамсартай болгон хүмүүжүүлэх” бодлого хэрэгжүүлж байв.
Үл ойлголцох үе (1962-1990)	60-аад оны эхнээс 80-аад оны эцэс хүртэл хоёр орны харилцаа муудаж зогсонги байдалд, 1966-1976 оны “соёлын хувьсгалын” үед хурцдаж сөргөлдөөний байдалд орсон. Энэ үед Хятадын зүгээс Монголын газар нутагт өнгөлзсөн халдлага гарч байсан учраас Хятадын аюулаас хамгаалахын тулд ЗХУ-ын цэргийн ангиудыг Монголын нутагт байрлуулсан төдийгүй Монгол дахь Хятад хэлний сургалт 10-аад жил завсарласан. 1964-1976 оныг судлаач Жу Ёншин боловсролын эмх замбараагүй үе гэж нэрлэн ямар ч онол үзэл баримтлалгүй, ололт амжилт гараагүй, академик хүрээнийхэн айдсын улмаас дуугүй байсан гэжээ. 1978-1990 оны хугацааг дахин сэргэлтийн үе. Хятадын боловсролын онолчид гадаадын боловсрол судлалын бүтээлүүд (бихеворизм, структурализм, прагматизм, экспериментализм, перенниализм, реализм, экзистенциализм, хюанизм, марксизм)-ыг орчуулж, үндэсний боловсролын үзэл санааг бий болгоход нөлөөлсөн оргил үед үед боловсролын социологи, философи, эдийн засаг, технологи, статистик, үнэлгээ хийгээд харьцуулсан боловсрол судлал Хятадад орж ирсэн юм.
Нээлтэй хамтын ажиллагааны хөгжлийн үе (1990-ээд оноос хойш өнөөг хүртэл)	МУ, БНХАУ-ын соёлын хамтын ажиллагааны гэрээ (1994) МУ БНХАУ 1998-2000 онд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төсөл (1998), Биеийн тамир спортын салбарт хамтран ажиллах тухай МУЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээр, Боловсролын үнэмлэх, эрдмийн зэргийн гэрчилгээг харилцан зөвшөөрөх тухай МУЗГ, БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээр, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Монголын оюутнуудыг сургах төслийг хэрэгжүүлэх хөтөлбөр (2000), МУ, БНХАУ 2001-2003 онд соёлын солилцоо, хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төсөл (2001), МУ, БНХАУ-ын ЗГ-аас 2004-2006 онд соёл урлагийн салбарт хамтран ажиллах ажлын төлөвлөгөө, МУ, БНХАУ 2005-2010 онд боловсролын солилцоо, хамтын ажиллагааны хөтөлбөр, МУЗГ, БНХАУ-ын ЗГ хооронд 2010-2013 онд хэрэгжүүлэх соёлын солилцооны төлөвлөгөөг тус тус хэрэгжүүлсэн.

Дүгнэлт

1949-1966 дипломат харилцаатай, улс төр, нийгэм, эдийн засаг, урлаг соёлын арга хэмжээнүүд өргөн хүрээтэй хэрэгжиж боловсролын хамтын ажиллагаанд маш их нөлөөлж байжээ. Албан ёсны баримтуудад 1952 оноос хоёр улсын боловсролын хамтын ажиллагаа эхэлсэн гэж үзсэн бөгөөд 1966-1976 онуудад хоёр улсын харилцаанаас улбаалан боловсролын харилцаа тасалдсан байна. 1991 оны улс төр, эдийн засгийн харилцаанаас түрүүлж 1986 онд боловсролын харилцаа сэргэж, 1994 онд Монгол Хятадын найрамдал хамтын ажиллагааны гэрээний дагуу “Сайн хөршийн харилцаа”-тай байснаа 2012 оноос стратегийн түншлэлийн

харилцаа нь боловсролын салбарт аргазүйн, эрхзүйн, хөрөнгө оруулалт зэрэг хэлбэрээр тасралтгүй өргөжиж байна.

Түүхэн баримтуудтай ажилласны үндсэнд хоёр улсын боловсролын хамтын ажиллагааг дараах байдлаар үечлэв. Үүнд: Нэгдүгээр үе социалист хамтын ажиллагаа (1949-1962) Хоёрдугаар үе Үл ойлголцох үе (1962-1990) ялангуяа 1966-1976 онд хоёр улсын харилцаа муудсанаас шалтгаалан боловсролын харилцаа, хамтын ажиллагаа зогсонги байдалтай байсан. Гуравдугаар үе Нээлтэй хамтын ажиллагааны хөгжлийн үе (1990-ээд оноос хойш өнөөг хүртэл) гэсэн түүхэн үечлэлийг тогтоов.

Хоёр улсын хамтын ажиллагаа нь худалдаа эдийн засаг, уул уурхай зэрэг салбарт хамгийн эрчимтэй хөгжиж, боловсролыг шинжлэх ухаан, соёл, технологи, хүмүүнлэгийн салбартай хамт нэгдсэн байдлаар хэрэгжүүлж байна. Хоёр улсын боловсролын хамтын ажиллагааны талаар дээд түвшний гэрээ хэлцэл, хоёр улсын түүхийн эх сурвалжаас өөр судалгаа, шинжилгээний баримт туйлын хомс байна.

Ашигласан материал

Болдбаатар, Ч. (2014). Монголын гадаад харилцаа. 114 дүгээр тал. Улаанбаатар

Жаргалсайхан, С. (2009). БНХАУ-ын дипломат бодлого, үндсэн зарчим, 14 дүгээр тал. Улаанбаатар

Монгол улс, Шинжлэх Ухааны Академи, (2006). Өнөөгийн Хятад №1

Очирбат, П. (1996). Монголын төр тусгаар тогтнолын түүхэн замнал. Улаанбаатар

McKenzie. (2008). Harnessing Educational Cooperation in the EAS for Regional Competitiveness and Community Building

Historical development of education cooperation between Mongolia and China

Ch.Baigalmaa^a, Qinggele^b

^aMongolian National University of Education

School of Education Studies, Department of Education Studies and Methodology,

^bHead of International Relations, Inner Mongolian Medical University

Abstract

Cooperation in educational sectors of two countries, Mongolia and China, has been extending intensively nowadays. However, it can be said that scientific research on educational cooperation of two countries has not been implemented. Therefore any publications such as research articles, books and dissertations about educational cooperation of two countries in two languages, Mongolian and Chinese, have not been published. This current situation requires intensification of academic research about this topic. This paper aimed to establish periodic and historical stages of educational cooperation between Mongolia and China from 1949 to 2017. We have analyzed historical documents or legal facts in two languages to reveal periods of historical stages of educational cooperation between Mongolia and China. Our study question was how to establish periodic stages of educational cooperation of Mongolia and China. As well as, we have extended research content of the subsector “educational history” by the content of historical development of educational cooperation between Mongolia and China. The study did data analysis, systematic analysis and comparative studies methods. The research findings indicated that educational cooperation of two countries has been extending covering many subsectors of education. It is recommended that educational researchers who are doing research under this topic need to be supported.

Key words

The historic stage on educational cooperation, socialist cooperation, ideologist and non-communication and friendly relationship (coactive) period